



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 1744

Улаанбаатар хот

Г Сургалт зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5 дахь заалт, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.7.6 дахь заалт, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэр дэх амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан "Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйлчилгээний технологи, стандарт" сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 1.000.000 /Нэг сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, Үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2016 оны 04 сарын 12-ны өдрийн ~~хуу~~ тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



**“АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗ, ГЭР БУУДЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ”
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн аялал жуулчлалын бүс болох Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагыг дээшлүүлэхэд сургалтын зорилго оршино.

Сургалтын агуулга: Сургалтын үеэр амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудад мөрдөгдөж байгаа стандарт, жуулчны болон хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй байдал, үйлчилгээний соёл, харилцаа зэрэг асуудлаар мэдээлэл хийнэ.

Хамрах хүрээ: Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудын удирдах албан тушаалтан болон менежерүүд.

Зохион байгуулагчид: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын ур чадварын мэргэжлийн сургууль

Хугацаа: 2015 оны 06-р сарын 24-ний өдөр 09.00-16.00 цагт

Хаана болох: Налайх дүүрэгт зохион байгуулагдана.

Хүрэх үр дүн: Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудын үйлчилгээний чанар, стандарт, жуулчны болон хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй байдал, ажилтнуудын харилцаа, хандлагын түвшинд ахиц гарна.


Сургалтын хөтөлбөр:

Хугацаа: 1 өдөр, онол 2 цаг, дадлага: 8 цаг, нийт 10 цаг

д/д	Бүлэг сэдэв	Сэдэв	Дадлага	Заах багш
1	Үйлчилгээний ажиллагсдад тавигдах шаардлага	Мэргэжлийн ёс зүй, тавигдах шаардлага	1	С. Нина
2		Жуулчны баазын стандарт, эрхзүйн зохицуулалт	1	Дүүрэг хариуцсан мэргэжилтэн
3	Жуулчны баазын жуулчин хүлээн авах албаны үйлчилгээ	Жуулчныг угтан авч, мэндчилэх	1	С. Нина
4		Жуулчдыг бүртгэх, байрлах гэр хуваарьлах, жуулчинд мэдээ мэдээлэл түгээх		
5		Жуулчдаас үндсэн болон нэмэлт үйлчилгээний захиалга авах		

6	Гэрийн цэвэрлэгээ үйлчилгээний технологи	Жуулчин байрлах гэрийн тавилга хэрэгслийн стандарт	1	С. Нина
7		Цэвэрлэгээний бодисын зааварчилгаа, хэрэглээ		
8		Жуулчин байрлаж буй гэрт үйлчлэх үйлчилгээ	2	
9		Жуулчин гарсан гэрийг цэвэрлэх үйлчилгээний технологи		
10		Жуулчин ирэхийн өмнөх үеийн цэвэрлэгээ үйлчилгээ		
11			Жуулчинд зориулсан эд хэрэглэлийн стандарт тавилт	
12	Жуулчны баазын угаалгын үйлчилгээ	Гэрийн цагаан хэрэглэлийн угаалга	2	С. Нина
13		Зоогийн газрын даавуун эдлэлийн угаалгын үйлчилгээ		
14		Жуулчны хувцас угаалгын үйлчилгээ		
15		Үйлчилгээний ажилтны дүрэмт хувцасны угаалга		
16		Угаалгын тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчилгаа		С. Нина
17	Аюулгүй байдал, эрүүл ахуй	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа	1	О.Отгонбаяр
Нийт			10	

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2016 оны 04 сарын 18-ны өдрийн ҮҮ тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



“АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗ, ГЭР БУУДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ” СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ /акад/цаг/	Нэгж үнэ	Нийт үнэ
1	“Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйлчилгээний технологи, стандарт” сургалт	10 акад/цаг	100.000	1.000.000
	Нийт дүн			1.000.000